



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/2021

Мандалговь

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль явагдаж байгаатай холбогдуулан 2021 оны 6 дугаар сарын 8, 9, 10-ны өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг хориглосугай.

2. Захирамжийг хэрэгжүүлж тухайн өдрүүдэд аймгийн нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулахгүй байх, бусад хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байхыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, ахуйн нэгжийн дарга, удирдлагуудад даалгасугай.

3. Сонгуулийн санал хураалтын үеэр иргэд, олон нийтийн хэв журмыг сахиулж, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, иргэд сонгогчдын аюулгүй байдлыг хангаж, захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210594